



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/70

Хэрлэн сум

“Шинэ өглөөг хамтдаа угтъя” үйл
ажиллагаанд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 8.1.3 дахь заалт, “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийтийн биеийн тамираар хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх зорилгын хүрээнд “Мөнхийн хайрын урсгал” ТББ-тай хамтран идэвхтэй дасгал хөдөлгөөн, амьдралын зөв дадал хэвшилтэй гэр бүл, иргэнийг олноор бий болгох, биеийн тамираар хичээллэгсдийг нэмэгдүүлэх” арга хэмжээний “Шинэ өглөөг хамтдаа угтъя” үйл ажиллагааны зардалд 5,000,000 (таван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.


3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн “Нийтийг хамарсан үндэсний болон нийтийн биеийн тамир, бүх нийтийн спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг түшиглэн биеийн тамираар хичээллэгсдийг нэмэгдүүлнэ” арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

02
1/70
Аймгийн Засаг даргын 2024 оны
дүгээр сарын 29-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт



“Шинэ өглөөг хамтдаа угъя” ажлын
хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Төсвийн задаргаа	Санхүүжилтийн хуваарь		Нийлбэр дүн
		2	6	
1	Дасгалын үйлчилгээ	2.000.000	1.000.000	3.000.000
2	Мэдлэг олгох сургалт	1.000.000	1.000.000	2.000.000
	Нийт	3.000.000	2.000.000	5.000.000